



АШУУИС
1942

Оюуны өмч, түүний тогтолцоо



Профессор Н.Сүмбэрзул

Суралцахуйн үр дүн

Энэхүү хичээлийг амжилттай дүүргэснээр:


- 1. Оюуны өмчийн тогтолцооны бүрэлдхүүн хэсгүүдийг дурьдаж, хоорондын уялдааг тайлбарладаг**
- 2. Судалгааны ажлын давхцал, түүнээс сэргийлэх арга замыг тайлбарладаг болно**

Агуулга

1. Оюуны өмч, түүний тогтолцоо

2. Хуулбарлалт, түүний хэлбэрүүд

3. Эшлэл, ишлэл авах аргууд





Оюуны өмч

Оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон

- зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект
- аж үйлдвэрийн өмч



Эх сурвалж: Монгол Улсын оюуны өмчийн тухай хуулийн
3.1.1 дэх заалт. <https://legalinfo.mn/mn/detail/15356>

Оюуны өмчийн хэлбэрүүд



Патент

**Шинэ бүтээл, технологийн
шинэчлэлийг хязгаарлагдмал
хугацаанд хамгаалах**



Худалдааны тэмдэг

**Бүтээгдэхүүн, үйлчилгээг
тодорхойлох брэнд, лого, ялгах
тэмдэгийг хамгаалах**



Зохиогчийн эрх

**Уран зохиол, жүжиг, хөгжим,
урлагийн бүтээл зэрэг
зохиогчийн эх бүтээлийг
хамгаалах**



Худалдааны нууц


**Өрсөлдөх давуу тал бүхий
бизнесийн нууц мэдээллийг
хамгаалах**

Оюуны өмчийн хэлбэрүүд

®
trademark



OMRON
OLYMPUS®



ОЮУНЫ ӨМЧИЙН ТОГТОЛЦОО



Технологи инновацийг дэмжих төв (Technology and innovation support center-TISC)

ТИДТ-үүд нь дараах үйл ажиллагааг үнэ төлбөргүй үзүүлэх бөгөөд зарим тохиолдолд төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно:

- Хэрэглэгчдэд шууд биечлэн харилцах замаар патентын мэдээллийн сан болон бусад техникийн мэдээллийн эх сурвалжид хайлт хийх үйлчилгээ үзүүлэх;
- Технологийн мэдээллээр хангах;
- Судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх;
- Технологи дамжуулалтыг боломжийг нээж илрүүлэх;
- Технологийн салбарын чиг хандлагыг тодорхойлох (төлбөртэй байж болно)
- Судалгааны үр дүнг боловсруулалтад оролцох (төлбөртэй байж болно)
- Аж үйлдвэрийн өмчийн эрхийн ялангуяа патентын тухай мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцох;

Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо (ASSOCIATION OF MONGOLIAN INTELLECTUAL PROPERTY AGENTS - AMIPA)

Үйл ажиллагааны чиглэл

- Оюуны өмчийн холбогдох хууль тогтоомжинд болон бодлогод санал боловсруулахад оролцох
- Оюуны өмчийн чиглэлээр мэдлэг мэргэшлийг дээшлүүлэхэд дэмжих
- Өөрийн орны хууль, дүрэм журмыг таниулан сурталчилах
- Оюуны өмчийн салбарыг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих бүхий л арга хэмжээ зохион байгуулах
- Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох

Эх сурвалж: <https://amipa.org.mn/>

Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт (MICA)

Үйл ажиллагааны чиглэл


1. Үнэлгээний үйл ажиллагааг төлөвшүүлэх,
2. Үнэлгээний үндэсний стандартыг боловсруулж мөрдүүлэх
3. Үнэлгээчид, үнэлгээний байгууллагуудын эрх ашгийг хамгаалах
4. Мэргэжлийн ёс зүйн дүрмийг чанд сахиулах
5. Үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлж, гишүүдийг мэдээллээр хангах,
6. Мэдлэг ур чадварыг тасралтгүй дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх,
7. Үнэлгээний ажлын чанарт хяналт тавих,
8. Гадаад харилцааг хөгжүүлэх.

Оюуны Өмчийн тогтолцооны ач холбогдол

Зохион бүтээгч болон эрх эзэмшигчийн **шинэ санаачлага, эрхийг хамгаалж иновацыг дэмжихэд** оршино.

Зохион бүтээгч болон эрх эзэмшигчид бүтээлээ бүтээх, ашиглах, худалдах, ашиг хүртэх, экспортлох онцгой **эрхийг засгийн газраас баталгаажуулан ирээдүйн орлогын боломжит урсгалыг тодорхой хугацаанд хамгаалж ашиг хүртэх боломжийг олгодог.**

Онцгой эрхийн хязгаарлагдмал хугацаа дууссаны дараа олон нийт зохион бүтээгчийн бүтээлийг ашиглах боломжтой болох ба энэхүү давуу талыг ашигласнаар **дараагийн шинэ бүтээлийг бий болгоход өдөөгч** болж байдаг.





M ccc lxxiiij. die xviij Martij. 32.

Sap Consilio. vj.
p. Marcon Cor mil.
p. Ludomus fustiz totor.
p. Paulus amozogara.
p. Zinzoni Justin mil.
p. Vital' lario dotiz mil.

Sap tre firme.
p. Anton' de prudis.
p. Lodomus fustio.
p. Zachar Barbaro mil.
p. Endricus trinisano.

Sono i questa Cita / et anche ala zornada p la grandeza et bonta da
Concorre homeri da diuersi bande / et acutissimi fragegni / apti ad excogitar
et trouar varij Ingegrosi artificij . Et sel fosse prouisto / che le opere et artificij
trouade da loro . altri viste che le hanesse / no podesseno farle se tuoz Honor
suo / Simel homeri exercitaziano linguo / troueziano / et faziario & le chosse /
che faziario de no picola vtilita et beneficio al stato nro . pero Landara parte
che p auctorita de questo ofero / chadaun che faza i questa Cita alcun nuouo
et Ingegroso artificio / no facto panti nel dno nro / Reducto chel fara a
pfection / Et che el se possi vsar / et exercitar sia teguido darlo i nota al officio
di nra prouedendo de Comm . Siando prohibito a chadaun altro i alcuna terra
e luogo nro / far alcun altro artificio / ad imagine et similitudine & quello senza
consentimento et licentia del auctor fino ad ani . x . Et tamen se alcun el fesse /
L auctor et Inuentor predito / habia liberta poderlo citar achadaun officio de
questa Cita / Salual officio el dicto / che hanesse cotrafacto / Sia astreto apagarli
dno Cento / et lartificio subito sia deffacto . Siando po i liberta de la nra signor
ad ogni suo praxer / tuoz et vsar ne / suo bisogni chadaun di dicti artificij / et
instrumenti / Cum questa po condition / che altri cha fauctori no li possi exatar .

de parte ——— 116
de non ——— 10 non sine — 3

Венецийн Сенат 1474 онд баталсан Венецийн патентын дүрэм

Энэ хотод оршин суудаг, мөн түүнчлэн түүний агуу байдал, сайн сайхан байдлын улмаас янз бүрийн газар нутгаас түр зуур ирсэн хамгийн ухаалаг оюун ухаантай, төрөл бүрийн ур чадвартай, зохион бүтээгч хүмүүс байдаг. Хэрэв манай улсад тэдний зохион бүтээсэн бүтээл, гаргасан шинэ санааг бусад нь бүтээж, гаргаж чадахгүй бол тэдгээр хүмүүс оюун ухаанаа дайчилж, бага ч гэсэн ашиг тустай зүйлийг зохион бүтээж болно. Иймд энэхүү Зөвлөлийн эрх мэдлийн дагуу энэ хотод бидний эзэмшилд урьд өмнө нь хийгдэж байгаагүй аливаа шинэ бүтээлийг төгс төгөлдөр болмогц нь хийж, ашиглах шийдвэр гарган энэ тухай манай Нийтийн эрх баригчдын албанд мэдэгдэнэ. Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр арав хүртэлх жилийн хугацаанд бусад хүмүүс үүнтэй төстэй хэлбэрээр өөр ямар нэгэн зохиомол бүтээлийг хийхийг манай улсын бүх нутаг дэвсгэрт хориглоно. Гэсэн хэдий ч, хэрэв хэн нэгэн үүнийг хийвэл зохиогч, зохион бүтээгч нь энэ хотын аль ч албан газарт энэ тухай мэдэгдэх эрхтэй бөгөөд тухайн албан газар нь зөрчсөн этгээд түүнд зуун дукаттай тэнцэх залилангийн төлбөрийг төлөх, хийсэн зүйлийг нэн даруй устгахыг албадна. Манай Засгийн газар зохиогдсон бүтээл, шинэ санааг өөрийн хэрэгцээнд ашиглах эрхтэй бөгөөд зохиогчоос өөр хэн ч ашиглах ёсгүй.

(Албан бус орчуулга. Н.Сүмбэрзул)

Шинэ бүтээлийн эрх зүйн зохицуулалт

- Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай “Парисын Конвенци” /1883/1985/
- Патентын хамтын ажиллагааны гэрээ /1991/
- Патентийн олон улсын ангиллын тухай "Страсбургийн хэлэлцээр" /2002/
- Патентын тухай хууль /2021-05-06/

Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт

- Оюуны өмчийн тухай хууль
- Зохиогчийн эрхийн тухай хууль
- Патентын хууль



Оюуны Өмчийн тухай хууль /2020.01.23/

Энэ хуулийн зорилт нь оюуны өмчийн эрхээр хамгаалагдах бүтээл, оюуны өмчийг хамгаалах зарчим, оюуны өмчийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тогтоох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахыг дэмжихтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.



Оюуны Өмчийн тухай хууль /2020.01.23/

7.1. Аж үйлдвэрийн өмчийн эрхэд дараах зүйл хамаарна:

- 7.1.1. шинэ бүтээл;
- 7.1.2. ашигтай загвар;
- 7.1.3. бүтээгдэхүүний загвар;
- 7.1.4. барааны тэмдэг;
- 7.1.5. газар зүйн заалт.

7.2. Аж үйлдвэрийн өмчийн эрх нь оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад эрхийн хамгаалалт хийлгэж, улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ.

7.3. Оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохих журмын дагуу энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3-т заасан зүйлийг бүртгэж патент, 7.1.4, 7.1.5-д заасан зүйлийг бүртгэж гэрчилгээ тус тус олгоно.



Зохиогчийн эрхийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлтэй холбоотой үүсэх зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, соёл, урлагийн бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор бүтээлийг ашиглах эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино



Зохиогчийн эрхийн тухай хууль

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.1.“зохиогч” гэж өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвисан хувь хүнийг;

4.1.2.“зохиогчийн эрх эзэмшигч” гэж зохиогч, энэ хуульд заасны дагуу шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг ашиглах онцгой эрхийг эдлэх бусад хувь хүн, хуулийн этгээд, эсхүл тэдгээрээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдийг;



Зохиогчийн эрхийн тухай хууль

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

4.1.3. “бүтээл” гэж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн салбар дахь зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааны бодит үр дүнг;

4.1.4. “үүсмэл бүтээл” гэж өмнө нь туурвисан бүтээлд тулгуурлаж өөрчлөн найруулах, орчуулах, хөрвүүлэх, хураангуйлах, эмхэтгэх болон бусад хэлбэрээр өөрчлөх бүтээлч үйл ажиллагааны үр дүнд шинээр бий болгосон бүтээлийг;



Зохиогчийн эрхийн тухай хууль

3 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.3."ашигтай загвар" гэж багаж, хэрэгсэл, түүнтэй адилтгах бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

3.1.4."бүтээгдэхүүний загвар" гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн уран сайхны шийдлийг;

3.1.17."шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг.



Патентын тухай хууль

Шинэ бүтээл, ашигтай загварын хамгаалалт, шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг, түүнд хайлт, шүүлт хийх, бүтээгдэхүүний загварын хамгаалалт, патент олгох, патентын хүчинтэй хугацаа, патентын хураамж, олон улсын мэдүүлэг, патент эзэмшигчийн эрхийг хамгаалах зэрэг 9 бүлэг, 56 зүйлтэй 2021-05-06 өдрөөс хэрэгжиж эхэлсэн шинэчлэн найруулсан хууль юм.



Хайлт, мөн чанарын шүүлт



Бүтээлийг уншиж
судлах



Хайлт



Мөн чанарын шүүлт
(шийдвэр гаргах)

Олон улсын
ангилал

Түлхүүр үг




PATENTSCOPE- 115 сая



Europäisches
Patentamt
European
Patent Office
Office européen
des brevets

Espacenet - 150 сая



Томьёолол /эрхийн
хамгаалалтын
хүрээ/


Томъёолол /Бүрдлийн шүүлтийн өмнө/

1. Онъсон дөрөө нь морь (тэмээ, үхэр) унах үед эмээлийн хамтаар хэрэглэгдэх тоног хэрэгсэл юм.
2. Онъсон дөрөөний ялгаа нь морь (тэмээ, үхэр) унах үед унаач хүний хөл (гутал) дөрөөнд тээглэн гацаж морь малд чирэгдэн эрүүл мэнд амь насаа алдах эрсдлийг багасгах зорилгоор бүтээгдсэн.
3. Онъсон дөрөө нь уламжлалт дөрөөнөөс давхар сэнжтэйгээрэй ялгагдана
4. Онъсон дөрөө нь уламжлалт дөрөөнөөс таваг нь салдаг байдлаараа ялгагдана.
5. Уг дөрөө нь нугас (палец) бүхий таваг нь их ба бага сэнжинд онъс буюу соёонд түгжигддэг онцлогтой.
6. Дөрөөн таваг нь хоёр тийш гарсан тээглүүртэй байх ба тээглүүр нь бага сэнжний ацанд нэгталаараа нугсан холбоогоор бэхлэгдэх бөгөөд нөгөө тал нь мөн бага сэнжний ацанд сул орохоос гадана хоёр тээглүүр хоёулаа их сэнжний соёонд орж бэхлэгддэг.



Томьёолол /Бүрдлийн шүүлтийн дараа/

1. Онъсон дөрөөний ялгаа нь онъсон дөрөө нь их сэнж /1.1/, бага сэнж /1.3/, их сэнжний хажуу хэсэг /1.4/, соёт тээглүүр /1.5/, дөрөөнд тавагны гутал халтирахаас хамгаалах нүх /1.6/, дөрөөн таваг /1.7/, их бага сэнжний холбох нугас /1.8/, бага сэнж дөрөөн таваг хоёрыг холбох нугас /1.9/, дөрөөн тавагны тээглүүр /1.10/-ээс бүрдэх бөгөөд дөрөөн таваг нь хоёр тийш гарсан тээглүүртэй ба тээглүүр нь бага сэнжний ацанд нэг талаараа нугасан холбоогоор, нөгөө тал нь бага сэнжний ацанд сул орж хоёр тээглүүр хоёулаа их сэнжний соёт тээглүүрт орж бэхлэгдэнэ.
2. Онъсон дөрөөний томьёоллын 1 дүгээрийн ялгаа нь нугас бүхий таваг нь их бага сэнжинд орж түгжигдэнэ.
3. Онъсон дөрөөний томьёоллын 1 дүгээрийн ялгаа нь их сэнжнээс чирэгдэх тохиолдолд бага сэнж болон дөрөөн таваг хоёр 45⁰-ын налуу болж дөрөөн тавагны тээглүүр соёт тээглүүрээс мултарч дөрөөн таваг онгойж хүний хөлийг дөрөөнөөс салгана.





ПАТЕНТЫГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ ҮР АШГИЙГ ХЭРХЭН ХҮРТЭХ ВЭ?





Зохиогчийн эрхийн тухай хууль

4.1.19."хуулбарлах" гэж бүтээл, тоглолтын бичлэг, фонограмм, өргөн нэвтрүүлгийг нэг, түүнээс дээш тоогоор шууд болон шууд бусаар, аливаа арга, хэлбэрээр хувиан олшруулахыг, түр болон байнгын байдлаар цахим хэлбэрт хадгалахыг;



Зохиогчийн эрхийн тухай хууль

38.1. Бүтээлийн зүй ёсны ашиглалтыг нь зөрчихгүйгээр, зохиогчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүйгээр ашигласан дараах тохиолдлыг бүтээл ашиглах онцгой эрхийн зөрчилд тооцохгүй

38.1.4. архив, музей, номын санд хадгалагдаж байгаа бүтээлээс хэсэгчлэн ашиглах;



Зохиогчийн эрхийн тухай хууль

39.1. Олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах гэдэгт доор дурдсаныг хамааруулна:

39.1.1. хэвлэлийн тойм бэлтгэх зорилгоор нийтлэгдсэн бүтээлээс хэсэгчлэн ашиглах;



Зохиогчийн эрхийн тухай хууль

40 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах

40.1. Эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор бүтээлийг хэсэгчлэн ашиглах гэдэгт доор дурдсаныг хамааруулна:

40.1.1. шинжлэх ухааны судалгаа хийх, эрдэм шинжилгээний бүтээл туурвих, шүүмж бичих зорилгоор хэвлэгдсэн бүтээлээс эшлэл авч хэсэгчлэн ашиглах;

Доорх жишээнүүдээс аль 5-н тохиолдол нь бүтээлийн хуулбарлалт вэ?

- A.** Зохиогчийг нь дурдалгүйгээр богино хэмжээний бичвэрийг шууд хуулбарлаж бичих.
- B.** Өөрийнхөө бичсэн текстэн дээрээ багштайгаа хамтран ажиллаж сайжруулах.
- C.** Зохиогчийг нь дурдалгүйгээр өөр хэл дээр бичигдсэн текстийг орчуулан бичих.
- D.** Бичсэн хүнийг дурдалгүйгээр текстийнх нь үгсийн байрлал, өгүүлбэрийн байрлалыг өөрчилж, ойролцоо утгатай үгсээр орлуулж, үг нэмж засварлах.
- E.** Хэд хэдэн тусдаа текстийг уншиж доторх агуулгуудыг засварлан эх сурвалжийг дурдалгүйгээр шинээр текст болгож бичих
- F.** 3-4 өгүүлбэр текстийг шууд ишлэл хэлбэрээр авч бичээд, эх сурвалжыг нь дурдах.
- G.** Өөрийнхөө бичсэн текстийг өөр хэл рүү орчуулан бичиж ашиглах.
- H.** Өөрийн бичиж дүгнүүлсэн текстийг ашиглаж хуучин бичсэн текст гэдгийг тайлбарлалгүйгээр нэмж баяжуулан бичиж ашиглах.

Доорх жишээнүүдээс аль 5-н тохиолдол нь бүтээлийн хуулбарлалт вэ?

- A.** Зохиогчийг нь дурдалгүйгээр богино хэмжээний бичвэрийг шууд хуулбарлаж бичих.
- B.** Өөрийнхөө бичсэн текстэн дээрээ багштайгаа хамтран ажиллаж сайжруулах.
- C.** Зохиогчийг нь дурдалгүйгээр өөр хэл дээр бичигдсэн текстийг орчуулан бичих.
- D.** Бичсэн хүнийг дурдалгүйгээр текстийнх нь үгсийн байрлал, өгүүлбэрийн байрлалыг өөрчилж, ойролцоо утгатай үгсээр орлуулж, үг нэмж засварлах.
- E.** Хэд хэдэн тусдаа текстийг уншиж доторх агуулгуудыг засварлан эх сурвалжийг дурдалгүйгээр шинээр текст болгож бичих
- F.** 3-4 өгүүлбэр текстийг шууд ишлэл хэлбэрээр авч бичээд, эх сурвалжыг нь дурдах.
- G.** Өөрийнхөө бичсэн текстийг өөр хэл рүү орчуулан бичиж ашиглах.
- H.** Өөрийн бичиж дүгнүүлсэн текстийг ашиглаж хуучин бичсэн текст гэдгийг тайлбарлалгүйгээр нэмж баяжуулан бичиж ашиглах.

Бүтээлийн хуулбарлалтын хэлбэрүүд

- Шууд хуулбарлах
(өгүүлбэр, зургийг үг үсэггүй хуулах)
- Дам хуулбарлах
(санааг өөрийн үгээр өөрчлөн илэрхийлэх)
- Шигтгэн (mosaic) хуулбарлах
(олон эх үүсвэрээс өгүүлбэрийг хольж хуулах)



1. Эх сурвалжид бичигдсэн текст:

Анхны металл олдоцууд нь цул бөөм хэлбэртэй зэс эсвэл алт байсан нь гарцаагүй. Зэсийн улаавтар өнгө, алтны шаргал өнгө, тэдгээрийн энгийн чулуунаас ялгарч харагдах гялалзсан гадаргуу нь нүдэнд туссан нь лавтай. Металлыг анх олж илрүүлээд анхны байдлаар нь чимэглэл төдийгөөр хэрэглэж байсан гэж үздэг.

(Asimov, Isaac, Greenwood Press, 1979)



Жишээ 1

Анхны метал олдворууд нь том ширхэгтэй цэвэр метал байсан байх магадлалтай. Тэдгээр металлууд нь байгальд том томоороо олддог цөөн хэдэн металлуудад ордог. Анх олоод гоёл чимэглэлийн байдлаар хэрэглэж байгаад дараагаар нь илүү амьдралд ойр зориулалтаар ашиглэж болох арга замыг олсон байх.

Энэхүү жишээн дээр бичсэн хүн нь эх сурвалжийн текстийг бүхлээр нь ашиглаагүй, өөрийнхөө үгээр орлуулж бичсэн байна.

Хариулт: Эх сурвалжийг дурдаагүй тул бүтээлийн хуулбарлалтад тооцогдоно. Текст нь эх сурвалжийн тексттэй төстэй байгаа бөгөөд анхны зохиогчийн дэвшүүлсэн таамаглал, санаа, дүгнэлт ижил байна.

Жишээ 2

Анхны металл олдоцууд нь цул бөөм хэлбэртэй зэс эсвэл алт байсан нь гарцаагүй. Зэсийн улаавтар өнгө, алтны шаргал өнгө, тэдгээрийн энгийн чулуунаас ялгарч харагдах гялалзсан гадаргуу нь нүдэнд туссан нь лавтай. Металлыг анх олж илрүүлээд анхны байдлаар нь чимэглэл төдийгөөр хэрэглэж байсан гэж үздэг.

(Asimov, Isaac, Greenwood Press, 1979)

Энэхүү жишээн дээр эх сурвалжаа дурдсан байна.

Хариулт: Гэвч эх сурвалжаас шууд авсан текстээ “ ” хашилтад хийгээгүй тул бүтээлийн хуулбарлалт хийсэн байна гэж үзнэ. Түүнчлэн ишлэлдээ номын хуудас заагаагүй байна.

Жишээ 3

Хүдрээс олон төрлийн металл гаргаж авах техник нь гайхал төрүүлмээр. Гагцхүү юу хүн төрөлхтнийг металл гаргаж авахын тулд янз бүрээр туршилт хийж үзэхэд хүргэв? Isaac Asimov-ын бичсэнээр, анхны металл олдворууд нь байгальд цул бөөм байдалтай олддог алт болон зэс байсан байх магадлалтай. Түүнээс хойш өөр өөр төрлийн хүдэрээр юу хийж болох, хэрхэн олборлох туршилтууд хийгдэж эхэлсэн нь дамжиггүй.

(Asimov, Isaac, Greenwood Press, 1979)

Энэхүү жишээн дээр “ ” хашилт ашиглаагүй ба эх сурвалжаа дурдсан байна.

Хариулт: Энэ бол бүтээлийн хуулбарлалт биш. Asimov-ийн санааг өөрийн үгээр найруулан бичсэн бөгөөд эх сурвалжийг дурдсан байна. Мөн “Isaac Asimov-ын бичсэнээр” гэж эх сурвалжаа дурдан тексттэйгээ холбож өгсөн нь бичиж байгаа хүний өөрийн эргэцуулэл болон эх сурвалж дах зохиогчийн санаа хоёрын ялгааг салган харуулж уншихад илүү ойлгомжтой болгосон байна.

Жишээ 4

Хүн төрөлхтний алт болон гялалзсан гадаргуутай металлыг сонирхож эхэлсэн нь бүх түүхийн эхлэлээс улбаатай. Хүн төрөлхтөн өөр өөр төрлийн хүдрээс хэрхэн металл гаргаж авах тухай санааг олсныг бид өнөөдөр хэлж мэдэхгүй. Энэ талаар маш олон таамаглал байдаг. Газар дээр том томоороо оршдог металлуудыг анх олсон гэх хамгийн түгээмэл тайлбар бий. Боловсруулалт хийлгүйгээр олж болдог металлуудын нэг нь алт юм. Металлын талаар тодорхой хэмжээний ойлголттой болж ирснээр хүн төрөлхтөн цааш металл гаргаж авах арга замуудыг турших явцдаа илүү боловсронгуй аргачлалыг бий болгосон.

Эх сурвалж дурдаагүй, мөн анхны текст дээр үндэслэж бичсэн юм шиг харагдаж байна.

Хариулт: Яг бүтээлийн хуулбарлалт хийсэн эсэхийг шууд хэлэхэд төвөгтэй юм. Текстийн хувьд ижил биш, гэхдээ бичсэн хүн нь үнэхээр Asimov-ын номыг ашигласан бол эх сурвалжаа дурдах ёстой. Харин тэр номонд бичсэн дүгнэлтийг огт мэдэлгүйгээр энэ бичвэрийг үйлдсэн бол бүтээлийн хуулбарлалт хийсэн гэж үзэхгүй.

Жишээ 5

Хүн төрөлхтөн яаж анх төрөл бүрийн хүдрээс металл гаргаж авах гайхалтай санааг олсон байж болох нэг таамаглал гэвэл анхны металл олдвор нь газрын гадарга дээр бөөн хэсэг байдлаар оршин байдаг металл байсан гэж үздэг. Тийм байдлаар байгаль дээрээс шууд байдлаар буюу хүдэр боловсруулахгүйгээр олддог металл бол алт юм. Isaac Asimov энэ тухай доорх байдлаар тайлбарласан байна:

Анхны металл олдоцууд нь цул бөөм хэлбэртэй зэс эсвэл алт байсан нь гарцаагүй. Зэсийн улаавтар өнгө, алтны шаргал өнгө, тэдгээрийн энгийн чулуунаас ялгарч харагдах гялалзсан гадаргуу нь нүдэнд туссан нь лавтай. Металлыг анх олж илрүүлээд анхны байдлаар нь чимэглэл төдийгөөр хэрэглэж байсан гэж үздэг.

(Asimov, Isaac, Greenwood Press, 1979, p. 3)

Металлыг ийнхүү таньж эхэлснээс хойш хүн төрөлхтөн түүнийг эрж хайж, гаргаж авах арга замуудыг турших явцдаа илүү боловсронгуй аргачлалыг бий болгосон байна.

Эх сурвалжаас шууд авсан текстээ “ ” хашилтанд хийгээгүй ба дараагийн хэсгийг үргэлжлүүлэн бичихэд Asimov-ын ном сэдэл өгсөн нь тодорхой харагдаж байна.

Хариулт: Энэ бол урт текстээс шууд ишлэл авах зөв аргачлал юм. Үүнийг багц ишлэл (block quotation) гэж нэрлэх бөгөөд хашилтад хийх шаардлагагүй. Харин үүнээс богино, нэг эсвэл хоёр өгүүлбэр хэмжээний ишлэл байх тохиолдолд “ ” хашилтад хийж бичнэ. Үргэлжлүүлэн бичсэн хэсэгт Asimov-ын номын санаанаас нөлөөлсөн хэсгийг иш татсан байгаа тул дахин эх сурвалжыг дурдах шаардлагагүй.



turnitin



Бүх

Зураг

Видео

Богино видео

Газрын зураг

Веб

Ном

Дахиад ▾

Багаж хэрэгсэл ▾



Turnitin

<https://www.turnitin.com> · Энэ хуудсыг орчуул

Plagiarism Detector: Prevent Academic Misconduct | Turnitin

Our advanced AI writing detection technology is highly reliable and proficient in distinguishing between AI- and human-written text and is specialized for ...

Turnitin login page

We take your privacy very seriously. We do not share your ...

Log in to Turnitin

Forgotten your password? Click here. Need more help? Click ...

Create a Turnitin Account

AI Writing Detection

Turnitin's AI writing detection tool is built around a unique ...

Similarity

Features Overview. Turnitin Similarity helps students and ...

[turnitin.com-оос илүү олдлоо »](#)



turnitin.com.au

<https://www.turnitin.com.au> · Энэ хуудсыг орчуул

Log in - Turnitin

Deliver and grade all types of assessments from anywhere using this modern assessment platform.

Log in · iThenticate. This high-stakes plagiarism checking tool ...

Илэрцийн тухай



Turnitin, LLC

Үүсгэн байгуу

Үүсгэн байгуу



Create a User Profile

All users must have a user profile to use the service. Please select how you will be using Turnitin:

[Student](#)

[Teaching Assistant](#)

[Instructor](#)

[Existing user?](#)

If you've used the service before, there is no requirement to create a new user profile. Log in [here](#) with your old credentials.



Create a New Student Profile

Class ID Information

All students must be enrolled in an active class. To enroll in a class, please enter the class ID number and class enrollment key that you were given by your instructor.

Please note that the key and pincode are case-sensitive. If you do not have this information, or the information you are entering appears to be incorrect, please contact your instructor.

Class ID

48888494

Class enrollment key

Dundgovi2025

User Information

Your first name

Your last name

Display names as

☐ First name (Space) Last name (example: John Smith)

NOW VIEWING: [HOME](#) > [DUNDGOVI](#) > [STUDENTS](#)

About this page

The student list shows the students enrolled in your class. To add a student, click the add student link. If you would like to send an email to your class, click the email all students link. Click a student's name to view his or her submissions.

Students

[Add Student](#)[Upload Student List](#)[Email All Students](#)

Enrolled	Student name		User ID	Email address	Drop
01-Jun-2025	Zul Sumber		1177992127	sumberzulnyamjav@gmail.com	

All Papers ▾

	Title	Submission ID	Uploaded	Viewed	Grade	Similarity
	Abstract.docx	2611720258	March 11, 2025	✂		99%
	Даалгавар 102, Төрбат.d...	2607851699	March 7, 2025	✂		0%
ЭН	МОНГОЛ хураангуй	2607790447	March 7, 2025	✂		97%
	Yu.Ganbolor ABSTRACT.d...	2607677542	March 7, 2025	✂		100%
asuren	Doctor 101 L.Purevjargal ...	2600230708	February 27, 2025	✂		3%
aa	Даалгавар, 101 Ч.Долгор...	2600181167	February 27, 2025	✂		0%
	Даалгавар 2	2599281333	February 26, 2025	✂		16%
Ү	ABSTRACT D-102 B.Baat...	2599224230	February 26, 2025	✂		100%
адрал	П.Мөнхбадрал V05.docx	2599126296	February 26, 2025	✂		90%
окаргал	Prevalence study of the us...	2599051256	February 26, 2025	✂		3%
	2016 оны 6 сараас 2017 ...	2599015403	February 26, 2025	✂		0%
il	Abstract - Nurmaa.docx	2598999673	February 26, 2025	✂		93%
a	Comparative study on wet ...	2598929688	February 26, 2025	✂		100%
atar	ABSTARCT.docx	2598878823	February 26, 2025	✂		100%
ren	Abstract Munkhzul	2598304634	February 25, 2025	✂		83%
suren	The impact of older perso...	2598296138	February 25, 2025	✂		89%

Ахмад настнуудын дунд халдварт бус өвчлөл өндөр, нэг ахмад настанд 2-3 архаг өвчин хавсарсан байх нь асаргаа сувилгааны хамаарал нэмэгдэх үндэс болж байна. Настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээг тодорхойлоход амралтанд явах, сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдах, улсын сувилалд сувилуулах, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, гэрээрээ асаргаа сувилгаа хийлгүүлэх хэмээн ихэнх нь нэрлэсэн байна. Монгол улсын ахмад настан эмнэлгийн үйлчилгээг гэрээр болон өдрийн үйлчилгээгээр авах сонирхол нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээс илүү байна.

Монголчууд ахмад настнаа асран хүндэлж, өтөл буурай болтол нь хамтдаа амьдран үг сургаалийг нь дагаж хүндэтгэн ирсэн нүүдлийн соёл иргэншлийнхээ хүрээнд асран хамгаалах үүрэг нь эхнэр нөхрийн аль нэг, 2үү, охин, ач, зээ, бэр зэрэгт оногддог ба энэ нь өнөөгийн суурин соёл иргэншилд урт хугацаагаар ахмад настанг асран хамгаалахад гэр бүлийн гишүүдийн үүрэг алдагдан, албан ёсны асран хамгаалагч болж улмаар бие махбодь, сэтгэл санаа, нийгмийн харилцаа болоод санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлдөг.

1 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод ахмад настанд 1 удаан хугацаагаар тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулах, өндөр настнуудыг халамжлах төрөл бүрийн үйлчилгээг бий болгох, асран халамжлагчдад дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

Match Overview

16%

< >

1	nhrcm.gov.mn Internet Source	8% >
2	Submitted to Mongolia... Student Paper	5% >
3	om.mohs.gov.mn Internet Source	1% >
4	chd18horoo.pms.mn Internet Source	<1% >
5	ikh-urog.blogspot.com Internet Source	<1% >
6	shuurga.mn Internet Source	<1% >
7	www.slideshare.net Internet Source	<1% >

АШУУИС-ийн Төгсөлтийн сургалтанд ашигладаг загвар

МОНГОЛ УЛСЫН
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 1/28

Улаанбаатар хот

Журам батлах тухай

АШУУ
өдрийн 21/02

1. "Ан:
үйл ажиллаг

4.9 Номзүй ба эшлэл

- 4.9.1 Эшлэл болон номзүйн бичилтийг JAMA (AMA)- Journal of American Medical Association загвараар бичнэ (Ном зүйн программ хангамж ашиглана. Жишээ нь: Endnote, Mendeley гэх мэт) Номзүйн бичвэрийг arial фонтоор 10 pt хэмжээтэй бичих ба мөр хоорондын зай 1 pt байна.
- 4.9.2 Эшлэлийг эх бичвэрт эшлэсэн дарааллын дагуу бичнэ. Эх бичвэрт эшлэлийн дугаарыг цэгийн дараа зай авахгүйгээр бичнэ.
- 4.9.3 Өмнө нь эшлэл татсан материал дахин тэмдэглэх тохиолдолд уг эшлэлийн анхны дугаарыг давтан тэмдэглэнэ.
- 4.9.4 Дараалсан олон эшлэл авсан тохиолдолд¹⁻³, дараалаагүй олон эшлэл авсан тохиолдолд^{1,3,8,10} гэж тэмдэглэнэ.
- 4.9.5 Веб хаягаас эшлэл авсан тохиолдолд веб эшлэлийн архив <https://www.webcitation.org/> -аар ном зүйд тэмдэглэн оруулна.

The Harvard Style

Харвард стандарт нь зохиогч-он гэсэн загвартай систем бөгөөд ишлэсэн текстийн араас тэмдэглэгддэгээрээ онцлогтой. APA стандарттай төстэй гэхдээ зохиолч болон хэвлэсэн он хоёрын дунд таслал тавьдаггүй.

Бичвэр доторх эх сурвалж

Зохиолчийн нэр болон хэвлэгдсэн оныг бичнэ, хэрэв шууд ишлэл эсвэл тодорхой тоо баримт гэх мэт байвал тухайн хуудасны дугаарыг мөн дурдана. Ингэснээр уншигч таны бичсэн зүйлийн тухай олох гэж эх сурвалжийг бүхэлд нь унших шаардлагагүй болно. Эх сурвалжийг хаалтанд бичнэ (**Lazar 2006, p.34**). Хэрэв 34 болон 35 дугаар хуудсуудыг ашигласан бол **pp.34-35** гэж бичнэ. Хэрэв нэгээс олон хуудсыг дурдах бол **p.34 et seq** гэж бичнэ. Мөн хуудас гэснийг илтгэх “**p**” үсгийг “**:**” тэмдгээр орлуулж болно (**Lazar 2006:34**). Хэрэв нэг ишлэлийг олон удаа давтан бичиж байгаа бол хуудасны дугаар бичихгүй байж болно (**Lazar 2006**). Нэгээс илүү, дөрвөөс бага зохиогчтой бол дараах байдлаар бичнэ: (**Smith & Jones 2010**). Дөрвөөс олон зохиогчтой бол дараах байдлаар бичнэ (**Smith et al. 2010**) эсвэл өгүүлбэр дотор **Smith et al. (2010)**

(Эх сурвалж: <http://owl.massey.ac.nz/referencing/harvard-style.php>)

Ном зүй:

Ном

Зохиогч, он, номын нэр, хэвлэсэн байгууллагын нэр, хэвлэсэн газар

Нийтлэл

Зохиогч, он, нийтлэлийн нэр, хэвлэлийн нэр, хэвлэлтийн дугаар, хуудас

Цахим нийтлэл

Зохиогч, он, нийтлэлийн нэр, хэвлэлийн нэр, хэвлэлтийн дугаар, хуудас, вэб хаяг

The APA Style

Харвард стандарттай төстэй боловч зохиогч болон он хоёрын дунд таслал тавьдгаараа ялгаатай.

Эх сурвалж: <https://libguides.murdoch.edu.au/APA>

Бичвэр доторх эх сурвалж

Зохиолчийн нэр болон хэвлэгдсэн оныг бичнэ, хэрэв шууд ишлэл эсвэл тодорхой тоо баримт гэх мэт байвал тухайн хуудасны дугаарыг мөн дурдана. Ингэснээр уншигч таны бичсэн зүйлийн тухай олох гэж эх сурвалжийг бүхэлд нь унших шаардлагагүй болно. Эх сурвалжийг хаалтанд бичнэ (**Lazar, 2006, p.34**). Хэрэв 34 болон 35 дугаар хуудсуудыг ашигласан бол **pp.34-35** гэж бичнэ. Хэрэв нэгээс олон хуудсыг дурдах бол **p.34 et seq** гэж бичнэ. Мөн хуудас гэснийг илтгэх “**p**” үсгийг “**:**” тэмдгээр орлуулж болно (**Lazar, 2006:34**). Хэрэв нэг ишлэлийг олон удаа давтан бичиж байгаа бол хуудасны дугаар бичихгүй байж болно (**Lazar, 2006**). Нэгээс илүү, дөрвөөс бага зохиогчтой бол дараах байдлаар бичнэ: (**Smith & Jones, 2010**). Дөрвөөс олон зохиогчтой бол дараах байдлаар бичнэ (**Smith et al., 2010**) эсвэл өгүүлбэр дотор **Smith et al., (2010)**

(Эх сурвалж: <http://owl.massey.ac.nz/referencing/harvard-style.php>)

Ном зүй:

Ном

Зохиогч, он, номын нэр, хэвлэсэн байгууллагын нэр, хэвлэсэн газар

Нийтлэл

Зохиогч, он, нийтлэлийн нэр, хэвлэлийн нэр, хэвлэлтийн дугаар, хуудас

Цахим нийтлэл

Зохиогч, он, нийтлэлийн нэр, хэвлэлийн нэр, хэвлэлтийн дугаар, хуудас, вэб хаяг

The Oxford Style

Оксфорд стандарт нь зүүлт тайлбар (footnote) дээр үндэслэсэн систем бөгөөд бичвэр дунд иш татсан хэсгийн баруун дээд байрлалд тоо бичиж эх сурвалжаа дурдах арга юм.

Бичвэр доторх эх сурвалж

Ишлэлийн төгсгөлд бичсэн тоо нь тухайн хуудасны доод хэсэгт (footer) эсвэл бичвэрийн төгсгөлд дэлгэрүүлж бичсэн эх сурвалжийг заасан байдаг. Уншигчид гол төлөв уншиж байхдаа нэгэн зэрэг зүүлт тайлбарыг харахыг илүүд үздэг учраас хуудас бүрийн доод хэсэгт эх сурвалжийг бичих нь илүү түгээмэл байдаг.

Ашиглаж байгаа эх сурвалжийн төрлөөс (ном, нийтлэл, цахим хуудас гэх мэт) хамаарч формат өөр өөр байх боломжтой тул урьд өмнө нь хэвлэгдэж байсан бичвэрүүдийг анзаараарай.

Эх сурвалж: <https://www.ub.umu.se/en/write/references/writing-references-oxford>

Ном зүй:

Ном

² Зохиогч, номын нэр, хэвлэлтийн дугаар, хэвлэсэн газар, хэвлэгчийн нэр, хэвлэсэн он

Цахим ном

² Зохиогч, номын нэр, хэвлэлтийн дугаар, хэвлэсэн газар, хэвлэгчийн нэр, хэвлэсэн он, вэб хаяг, хандсан огноо

Сэтгүүлийн нийтлэл

² Зохиогч (овог нэр), нийтлэлийн нэр, сэтгүүлийн нэр, хэвлэлтийн дугаар, хэвлэсэн он, хуудасны дугаар

Цахим хуудас

² Зохиогч хувь хүн эсвэл байгууллагын нэр, он, гарчиг, цахим хуудасны нэр, сүүлд шинэчлэгдсэн огноо, цахим хаяг, хандсан огноо

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭХ СУРВАЛЖУУД:

The JAMA Style

<https://libguides.newcastle.edu.au/jama/in-text>

<https://libguides.newcastle.edu.au/jama/reference-list>

The Harvard Style:

www.owll.massey.ac.nz/referencing/harvard-style.php

www.wikihow.com/Cite-Using-the-Harvard-Style

The Oxford Style:

www.ub.umu.se/en/write/references/writing-references-oxford

www.wikihow.com/Reference-in-Oxford-Style

www.ox.ac.uk/public-affairs/style-guide?wssl=1

The IEEE Style:

libraryguides.vu.edu.au/ieeereferencing/gettingstarted

The APA Style:

www.wikihow.com/Cite-a-Textbook-in-APA

owll.massey.ac.nz/referencing/apa-style.php

The MLA Style:

www.wikihow.com/Quote-and-Cite-a-Play-in-an-Essay-Using-MLA-Format

owll.massey.ac.nz/referencing/mla-style.php

Суралцахуйн үр дүн

Энэхүү хичээлийг амжилттай дүүргэсэн БИ:

Тийм

Үгүй

1. . Оюуны өмчийн тогтолцооны бүрэлдхүүн хэсгүүдийг дурьдаж, хоорондын уялдааг тайлбарлаж чадна

☐☐

2. Судалгааны ажлын давхцал, түүнээс сэргийлэх арга замыг тайлбарлаж чадна

☐☐



АШУУИС
1942



Анхаарал тавьсанд баярлалаа